



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/354

Чингис хот

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нэгдсэн эмнэлгийн 61 750 000 төгрөгийн балансын үнэтэй, 61 750 000 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй үлдэх өртөггүй автомашиныг анхны батлагдсан үнэ 1 000 000 төгрөгийг 50 хувиар үнэ бууруулж 500 000 төгрөгөөр худалдсугай.

2. Үнэ бууруулан худалдах хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                       |            |  |
|-----------------------|------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Н. Үнэнбат | Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Хөтлөгч:              | С.Энхцэцэг | Орон нутгийн өмчийн газрын Мэргэжилтэн                               |
| Тэмдэглэл хөтлөгч:    | Л.Оюунтуяа | Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч, бичиг хэрэг               |

3. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 10:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 304 тоот өрөөнд зохион байгуулсугай

4. Эд хөрөнгийг үнэ бууруулан худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Үнэнбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

23102